

“УУЛ УУРХАЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖ, ХЭРЭГЖИЛТ”

СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Ховд аймаг, Жаргалант
2019 оны 6 дугаар сарын 26-27-ны өдөр



УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



САСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖИЛЭГЧ АГЕНТЛАГ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР



СЕСМИМ
ТӨСӨЛ
МОНГОЛ УСЫН ОБОРВОХ САЛБАРЫН
МЕНЕЖМЕНТИЙГ ХАЖУУЛАХ ТӨСӨЛ

Сэдэв:
“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай
ба Орон нутаг”

Г.Сурахбаяр,
СЕСМИМ Төслийн ахлах
зөвлөх

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

Зорилго...

- ❖ Монгол Улс цэцэглэн хөгжихэд Уул уурхайн салбар, түүний хөгжлийн түүчээнд орон нутгийн оролцоо, хамтын ажиллагаа, харилцан багана болж тулгын чулууных нь нэг байх..., үр дүнд нь Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал биелэхэд бодит түлхэц болох тухай

Зорилт

- ❖ Бодлого, хууль, эрх зүйн зохицуулалт, зорилт, харилцаа, уялдаа, жишээ, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, цаашид шийдвэрлэхэд чиг хандлага, ойлголтоо нэгтгэх, хамтран ажиллах, сайжруулах, үр дүн гаргахыг эрмэлзэх

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

АГУУЛГА

- ❖ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ 2030
- ❖ ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО 2014-2025
- ❖ САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ
- ❖ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ МЕХАНИЗМ САЙЖРУУЛАХ нь
- ❖ ЖИШЭЭ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ,
- ❖ ШААРДЛАГА, ХЭРЭГЦЭЭ: ДҮГНЭЛТ

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ 2030

- ❖ “Тогтвортой хөгжил -2030 хөтөлбөр”-ийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод улс орнуудын төрийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын “Тогтвортой хөгжил” бага хурлын үеэр санаачилсан.
- ❖ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан.
- ❖ Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр Монгол Улс нь 2030 онд:
 - ❖ “...Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 17,500 америк долларт хүрч, нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрнэ...,”
 - ❖ “...Эдийн засгийн жилийн дундаж өсөлт 2016-2030 онд 6.6 хувиас доошгүй байна...,”
 - ❖ “...Бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр дэлхийн эхний 40, өрсөлдөх чадварын үзүүлэлтээр эхний 70 орны нэг болно...”

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ 2030

ТХЗ-ын уриа:

Хөгжлөөс хэн ч үлдэх, хоцрох ёсгүй.

“**NO-ONE** left behind”



НИЙГЭМ



ЭДИЙН ЗАСАГ




БАЙГАЛЬ ОРЧИН

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ 2030

ТХЗ-ын хэрэгжилтийг хангахад ОРОЛЦОХ ИНСТИТУЦИУД

ТХЗ-ыг хэрэгжилтийг хангахад улс орнуудын засгийн газар, яамд, төрийн бусад байгууллагууд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, орон нутгийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, холбогдох бусад байгууллагууд болон иргэд оролцоно.



“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГО 2014-2025

- 1.1.Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого нь хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэнэ.
- 1.3.Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг бусад салбарын бодлоготой харилцан уялдуулан хөгжүүлнэ.
- **3.1.7.ил тод байдлын болон хариуцлагатай уул уурхай, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ зэрэг олон улсын санаачилгыг дэмжин хөгжүүлэх;**

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГО 2014-2025

3.5.Орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд:

- 3.5.1.тухайн нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолт эхлүүлэхийн өмнө хөрөнгө оруулагч, орон нутгийн иргэдийн хоорондын харилцан ойлголцох нөхцөлийг бүрдүүлэх, уул уурхайн төслийн нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулах ажилд орон нутгийн удирдлагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх;
- 3.5.2.уул уурхайн олборлолтын хугацаанд нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулагч компани, нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд орон нутгийг хөгжүүлэх гэрээг ил тод байх, оролцооны зарчмыг баримтлан байгуулах.

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГО 2014-2025

3.6.Байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн хүрээнд:

- 3.6.1.олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийн үе шатуудад хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, хүрээлэн байгаа орчны экологийн тэнцвэрт байдлыг хангасан байх;
- 3.6.2.төрийн өмчийн аж ахуйн нэгж нь ерөнхий гэрээлэгчийн зарчмаар ажиллаж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг хэрэгжүүлэх;
- 3.6.3.уурхайн нөхөн сэргээлт, хаалтын стандарт, журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах;
- 3.6.4.эрдэс баялгийн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлд газрын гүний цэнгэг усыг аль болох ашиглахгүй байх, гадаргын усыг түлхүү ашиглах, холбогдох хуульд заасны дагуу хэрэглэсэн усыг дахин ашиглах, уул уурхайн салбарын ахуйн хэрэглээнд саарал усыг ашиглах, орчин үеийн дэвшилтэт технологийг дэмжих;
- 3.6.5.олборлох, боловсруулах үйлдвэрийн хаягдлыг дахин боловсруулахад хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, үр ашигтай техник, технологи хэрэглэхийг дэмжих.

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГО 2014-2025

4.3.Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн:

- 4.3.1.геологийн судалгаа, хайгуулын ажлыг төрийн бодлогын дагуу гүйцэтгэж, улсын эрдэс баялгийн нөөцийг өсгөж, уул уурхайн салбарын урт хугацааны тогтвортой хөгжлийн суурийг бүрдүүлэх;
- 4.3.5.томоохон хэмжээний үйлдвэрлэлийн төвүүд бий болсноор хүн амын хэт төвлөрөл саарах;
- 4.3.9.эрдэс баялгийн салбарын бүх шатны үйл ажиллагаа нь хууль, журмын дагуу явагдаж олон нийтэд нээлттэй, ил тод байж, шинээр хууль тогтоомж, журам боловсруулах, томоохон хэмжээний төсөл хэрэгжүүлэхэд олон нийтийн саналыг хүлээн авч, шийдвэр гаргахад тусгаж байх эрх зүйн орчин бүрдсэн байх;

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

ТҮҮХЭН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

- 1913 оны Богд хаант Монгол Улсын Уурхайн дүрэм
- 1924 оны Ардын засагт Монгол Улсын Уурхайн дүрэм
- 1994 оны Ашигт малтмалын тухай хууль
- 1997 оны Ашигт малтмалын тухай хууль

ХҮЧИН ТӨГӨЛДӨР:

- 1992 оны Үндсэн хууль
- 1987 оны Газрын хэвлийн тухай хууль
- 2006 оны Ашигт малтмалын тухай хууль
- Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Захиргааны ерөнхий хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Иргэний хууль, Хөдөлмөрийн хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай болон холбогдох бусад хууль, дагалдан гарсан журам, дүрэм

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

Монгол Улсын Үндсэн хууль ба 2006 оны Ашигт малтмалын тухай хууль:

- Монгол Улсын Үндсэн хуулийн 16.1.2-д “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”
- Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “Газрын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргах.
- Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6-д “хайгуулын ажлын явцад байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай баримт;
- Ашигт малтмалын тухай хуулийн 38, 39 дүгээр зүйлүүдэд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах талаарх үүргийг тусгасан байдаг.

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ МЕХАНИЗМ: ИРГЭН, ОРОН НУТАГ, БАЙГАЛЬ ОРЧИН

БОНБНУ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

БОНБҮ тухай хуулийн 8.4.8

нарийвчилсан үнэлгээний тайланд төсөл хэрэгжих

- нутаг дэвсгэрийн захиргаа,
- төслийн нөлөөлөлд өртөх нутгийн ИНХ-ын санал, тэмдэглэл

”Нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд”-төслийн нөлөөлөлд шууд ба шууд бус хэлбэрээр өртсөн болон өртөж болзошгүй тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд

БОННУ-ний судалгаанд олон нийтийн оролцоог хангах үүрэг-үнэлгээ хийх эрх бүхий ААН

БОНХ-ийн сайдын 2014 оны А-03 тоот тушаалаар “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ МЕХАНИЗМ: ИРГЭН, ОРОН НУТАГ, БАЙГАЛЬ ОРЧИН

НИЙГМИЙН БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

БОНБНҮТХ, 8.4.5. БОНБНҮ-нд тусгах зүйл:

төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрсдэлийн үнэлгээ;

ЗГ-ын тогтоол: 2013 оны 374 тогтоол: Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам

5.4. БОМТ (ЗД-д хүргүүлдэг)ний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг төслийн бүх үе шатанд хэрэгжүүлнэ. Хөтөлбөрт дараах асуудлыг нарийвчлан тусгасан байна:

5.4.1. нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ МЕХАНИЗМ: ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

Ашигт малтмалын тухай хуулийн 42.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

байгаль орчныг хамгаалах

уурхай ашиглах, үйлдвэр
байгуулахтай холбогдсон дэд
бүтцийг хөгжүүлэх

ажлын байр нэмэгдүүлэх

Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.10: Гэрээний загварыг батлах эрхийг Засгийн газарт олгосны дагуу Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан гэрээний загвараар гэрээ байгуулагдаж байна.

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ МЕХАНИЗМ: ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

| Нутгийн захиргаанд | Иргэдэд | Компанид |
|---|--|---|
| Орон нутгийн хөгжлийг хангах | Ажлын байр, бизнесийн боломж нэмэгдүүлэх | Итгэлцэл |
| Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх | Дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах | Орон нутгаас дэмжлэг авах Нийгмийн зөвшөөрөл |
| Хуулийн хэрэгжилтийг хангах/ Хяналт тавихад хялбар болох | Мэдээлэл авах, оролцох, хянах | Хууль бус дарамт, шаардлагаас хамгаалагдана |
| Олон талын мэдээлэл авах | Компани нутгийн захиргааны хариуцлагыг нэмэгдүүлэх | Хуулийн дагуу, чөлөөтэй ажиллах нөхцөл бүрдэнэ |
| Ард иргэдийнхээ дэмжлэгийг авах | Байгаль орчны болон бусад эрхийн зөрчлөөс сэргийлэх | Тогтвортой, хэвийн үйл ажиллагаа |

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ МЕХАНИЗМ: ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

- *Гэрээ байгуулагдахгүй байх*
- *Нутгийн захиргааны байгууллага*
- *Гэрээ аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд нийцэхгүй*
- *Нутгийн иргэд гэрээ байгуулагдсан тухай мэдээлэл байхгүй*
- *Иргэд, иргэдийн бүлэг хоорондын зөрчилдөөн*
- *Талууд хоорондын зөрчилдөөн (компани-иргэд, иргэд-төр засаг)*
- *Оролцогч талуудын чадварын зөрүүтэй байдал*
- *Ил тод байдал, олон нийтийн оролцоо (сонсох ажиллагаа)*
- *Гэрээний хэрэгжилтийг тайлагнах*

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

ЖИШЭЭ: ӨМНӨХ ҮЕИЙН СУРГАМЖ

НАЛАЙХ ОРХИГДСОН УУРХАЙ

68,7 мянган га газартай бол үүний 3628,9 га газар орхигдсон. 160 нүх.

Орон нутаг зөвхөн хүн унахааргүй болгож хаадаг.

1995 онд улсаас өгөх татаас хумигдаж 111-р тогтоолоор хаагдсан.

Нийт хаагдсанаас хойш 205 хүн нас барсан.

1500 хүн гар аргаар уурхайн олборлож байна. 18-35 насны залуус

Нийт 69 А лиценз, 19 Х лиценз.

2014 онд хүчээр хаах гэж оролдсон.

Нутгийн иргэд эсэргүүцэж хаалгаагүй. Мөргөлдөөн



“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

ЖИШЭЭ5 ОРЧИН ҮЕИЙН АСУУДЛУУД




“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ 2030



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

МУТХҮБ-2030-г хэрэгжүүлэх төлөвлөгөөний зорилт




“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Уул уурхай ба Орон нутаг”

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: Хойч үеийн хэрэгцээг хязгаарлахгүйгээр өнөөдрийн хэрэгцээгээ хангаж чадах хөгжил-эдийн засаг, байгаль орчин, нийгмийн тэнцвэртэй хөгжил

Дүгнэлт: Салбарын эрх зүйн орчныг сайжруулах замаар Уул уурхай ба Орон нутгийн харилцаа, хамтын ажиллагааг улам бүр зүгшрүүлэх шаардлагатай байна.





**МОНГОЛ УЛС ҮҮРД ЦЭЦЭГЛЭН ХӨГЖИЖ, МОНГОЛ ХҮН
БҮР ЭРҮҮЛ ЭНХ, ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ, АЗ
ЖАРГАЛТАЙ АМЬДРАХ НӨХЦЛИЙН ТӨЛӨӨ УУЛ
УУРХАЙН САЛБАРАА, ТҮҮНЧЛЭН ОРОН НУТГАА
ХӨГЖҮҮЛЖ ХАМТРАН АЖИЛЛАЦГААЯ**

Баярлалаа